

СИЛИКАТ ХК-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Силикат” ХК-ийн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхний амар амгаланг айлтган мэндчилж байна.

1. Компанийн ерөнхий тойм:

- Силикат ХК нь 1966 онд Польш улсын хөрөнгө оруулалтаар “Силикат тоосго, шохойн үйлдвэр” нэрээр Дархан хотын анхны аж үйлдвэр болон байгуулагдсан.
- 1966 оноос 1992 он хүртэл тасралтгүй ажилласан ба тухайн үеийн Монгол улсын ханын материалын хэрэгцээний 25%-ийг дангаар хангаж байсан түүхтэй.
- 2006 онд Силикат цагаан тоосгоны дамжлагыг Силикат хөнгөн блокны үйлдвэр болгон шинэчилсэн. Тэр үэс хойш хөнгөн бетон үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2. Силикат үйлдвэрийн бааз суурь:

- “Силикат” ХК-ны үйлдвэрийн байр нь Дархан хотын үйлдвэрийн дүүрэгт өөрийн байранд байрладаг.
- Дархан-Уул аймаг, Улаанбаатар хот, Эрдэнэт, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ зэрэг төвийн бүсийн хэрэглэгчдэд авто замаар болон төмөр замаар хөнгөн бетон блок тээвэрлэн нийлүүлэх боломжтой.

3. Санхүүгийн чиглэлээр:

“Силикат” ХК нь 2021 онд санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тогтоосон хугацаанд гаргаж, санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулан харьяа татварын албаар хянуулж, зохих байгууллагуудад хүргүүлэн МУ-ын хууль тогтоомжийг мөрдөн ажиллалаа.

4. 2021 онд компанийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн ажлын тайланг та бүхэнд танилцуулъя.

Силикат үйлдвэрлэл:

- Автоклавын уур ёсөлт, шаралтын хугацаа, горимын технологийг чанд мөрдсөнөөр 35-36.5 кг жинтэй, бэлэн бүтээгдэхүүний стандартын шаардлагыг бүрэн хангасан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон.
- Силикат цехээс гарч байгаа бэлэн бүтээгдэхүүнийг гаднах талбайд цэгтэй хурааж, талбайн цэвэрлэгээг тогтмолжуулсан.

- Цехийн тэргэнцрийн зам ашиглалтыг нэмэгдүүллээ.

5. Үйлдвэрлэлийн дотоод орчин:

Түүхий эд материал:

КОВИД-19 цар тахалтай холбоотой түүхийн эд материал хомстож улмаар үнийн хэт өсөлтөөс болж татан авалт тасалдах зэрэг хүндрэлүүд гарсан.

Тоног төхөөрөмж:

Силикат үйлдвэр нь сүүлийн жилүүдэд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгээгүй учраас гар ажиллагаа их мөн элэгдэж хуучирснаас үүдэн эвдрэл гэмтэл их гарч байна. Иймд ажиллах хүчний зардал өндөр, сэлбэг хэрэгслийн олдоц муу, засварын зардал ондор байна.

Хүний нооц:

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа улирлын шинж чанартай явагдаж байгаа учраас ажилчдын тогтвортой суурьшил муу, ажиллах хүчний хомстол ихтэй байна. Тоног төхөөрөмжүүд гар ажиллагаа их учраас ажиллах хүчнээс шууд хамааралтай.

Тогтмол зардал:

Хэдийгээр цахилгаан, дулаан, уур усны Засгийн газрын хөнгөлөлт нь энэ жилийн үйл ажиллагаанд эрэггэр нөлөөлсөн ч Засгийн газрын хөнгөлөлт чөлөөлөлт зогсож, дээрх зардлуудын үнэ нь өсөх төлөвтэй байна. Энэхүү үйлдвэрлэлийн хэмжээгээ ихэсгэхгүй бол алдагдалтай ажиллахад хүрээд байна.

Гадаад орчны нолоолол:

Ойрын жилүүдэд шинэ хөнгөн блокны үйлдвэр олон тоогоор нэмэгдэж, бетон зуурмаг болон бусад шинэ төрлийн дүүргэгч материал ихээр зах зээлд нэвтэрч байна. Ийнхүү бид өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагатай байна.

КОВИД-19 цар тахалтай холбоотой түүхийн эд материалын татан авалт тасалдах зэрэг үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдах хүнд нөхцөл байдал үүсэж байгаа хэдий ч бид ажлын байрыг хадгалах бодлого баримталж, ажилчдаа 90 гаруй хувийг вакцинжуулалтад хамруулж, эрүүл мэндийг нь учир ч болох эрсдэлээс хамгаалах тал дээр онцгой анхаарч ажиллаж байна. Эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал мөн дээрх шалтгаануудаас үүдэн 2021 онд хувьцаа эзэмшигчдэд тараах ногдол ашгийг тодорхой хугацаагаар хойшлуулах санал ТУЗ-д танилцуулснаар хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг тараахгүй байх тухай шийдвэр гарсан.

“СИЛИКАТ” ХК